



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/396

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг
хязгаарлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Гишүүнчлэлийн журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2, "Гишүүнчлэлийн гэрээ"-ний 4 дүгээр зүйлийн 4.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК нь "Гишүүнчлэлийн журам"-аар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тул 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг авсугай.
2. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын алба (Ч.Эрдэнэболор)-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЦОГТБАЯР

1524030871